- 2010** “Монгол Урианхайн Хөөмий” түүхэн баримтат киног ШУА-ийн хэл шинжлэлийн хүрээлэн, Нүүдэлийн соёл иргэншлийг судлах хүрээлэнгийн эрдэмтэд болон Азийн бөөгийн холбоо, “Их хөгсүү” холбоотой хамтран хийлээ.
- 2011** Шведын дуучин, зураач Малин Шверижийн хамтаар Ириландын Саами үндэстэн нүүдэлчдийн өвөрмөц дуу, Якутын гүүргий, Индианы цоргот хөгжим, Алтайн нурууны бөлбөөлөх урлагийн зарим содон онцлогийг гаргасан цомгийн эх бэлджээ
- 2012** 1996 оноос хойш хайлсан Алтайн баатарлаг 13 туульсаа эмхэтгэж CD хийж ШУА-ын хэл зохиолчийн хүрээлэнгийн дуу авианы танхим, Соёлын өвийн төвд судалгааны хэрэглэгдэхүүн болгон өгчээ.
- 2013** АНУд тоглолтоо хийж, Харвардын их сургуульд тоглож, лекц уншиж, их сургуулын музейд үе дамжиж ирсэн хөгжмүүд нь тавигдав.

ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД, ЗАРИМ ОНЦЛОХ ТОГЛОЛТУУД

1992-1996 нийт Монгол туургатнуудад “Хамаг Монгол” тоглолт

- 1996** “Азийн аялгуу” тоглолт, лекц, Ташкент хот
- 1997** “Чингисийн үр сад” аялан тоглолт, Японы 28 хот
- 1998** “Элсний нүүдэл” аялан тоглолт, Сингапур, Индонез
- 1999** “Монгол Урианхай ёс заншил” эрдэм шинжилгээний хурал, Ховд хот
- 2000** “Аргил цагаан өвгөн” мөчлөг туулиа бүрэн эхээр нь хайлж соронзон хальсанд бичүүлэв
- 2001** “Хамаг Монгол”, “Өрлөг Зэлмэ” тоглолт, Польш, Болгар, Турк улс
Олон улсын хоолойн дууны наадам, Финлянд улс, Хэлсинг хот
- 2002** “Монгол Хүннүгийн Хөөмий, Цуурын гайхамшиг” аялан тоглолт, Араб, Турк улс
- 2003** “Алтан Ханасын” цуурын хөгөлгөө уулзалт, семинар
- 2004** Оросын “Батыхан” групптэй хамтран Египетед хийсэн соёлын арга хэмжээнд “Сүбээдэй” тоглолт хөтөлбөртэй оролцож “**Бөх Алтан Нудрам**” туулиа хайлжээ
“Монгол Жангар” тоглолт, дундад Азийн орнууд, Түвд
“Хоолойн эрдэм” тайлан тоглолт, Үрэмч хот
- 2005** “Туурайн төвөргөөн” наадам
Эрдэмтэн Б.Катуугийн хамт “**Алтай Чингэл баатар**” туулийг гар бичмэлээс нь сэргээж аудио бичлэгтэй нь ЭШ-ны эргэлтэнд оруулжээ.
“Эртний Ази” Фестиваль, Шанхай хот
“Монгол, Хүннү, Урианхай” аялан тоглолт, Япон улс, Токио, Осака хот
- 2006** Ховог сайрын “**Жангар**” туулийн хурал
Бад Эзеннерийн Обертон фестиваль, ХБНГУ
Азийн Бөөгийн холбооны 10 жилийн ойд зориулсан олон улсын хурлын ерөнхий зохион байгуулагчаар ажиллажээ.
Ховдын “**Алтайн туульс**” хөөмийн наадам
- 2007** “**Айдос**” наадам, симпозиум, Алма-Аты
Америкийн хүн судлаач Жеймс Анжел Крижтины хамт “**Уулын цуурай**” авиан судалгааны хөтөлбөр
“**Мөсний фестиваль**”, Аляск, Якут
- 2009** ОХУ-ын нэрт тууль судлаач Н.Биткеевийн урилгаар Волгоград хотноо 11 бүтэн туулийг туульсын хоржин хоолойгоор хайлжээ.
- 2009** Улаанбаатарын олон улсын хөөмийн симпозиумын нээлт
Эртний **Ром Итали, Испаны** угсаа залгамжилсан хүмүүст “Эх язгуур” тоглолт, хурал
ОХУ-н Тувагийн уран бүтээлчидтэй хамтарч Сингапурд хийсэн хурал “**Самгалдай**”, тоглолт
- 2010** Ардын урлагийн 5 төрөл дээр 37 хүнд сургалт, Ховд аймаг, Мөнххайрхан сум
Ойрад Монголын ардын урлагийн анхдугаар их наадмын нээлт
Хельсингийн язгууртаны ордны хөгжим судлалын хурлын тоглолт
“**Ойрд Монголын холбооны дэд тэргүүн**”, “Хөгсүү чуулгын” нарийн бичгийн даргын үүрэгт ажилд томилогдов.
“**Шинэ хөөмийн Ассоциаци**” байгууллагатай хамтран хөөмийгөө Монголын нэрээр буцааж батлуулах “Монгол хөөмий гайхамшиг” тоглолтын язгуур эхийн нээлтийг хийжээ.

2011 “Их хөгсүү” чуулгын бүрэлдэхүүнд 12 аймгийн төв бүх сумуудаар тайлан тоглолт хийлээ.

“Дээлтэй Монгол” наадам, Улаанбаатар

Хүннү гүрний 2220 жилийн улсын баярын нээлт

ХБНГУ-д Хоолойн дуу болон хөөмийн олон улсын наадам болон Дундад зууны фестивальд оролцож, Европын Итали, Франц, Швейцарь, Бельги, Голланд зэрэг улсад “Транс Монголиа” хамтлагтай болон дангаараа Монгол урлагаа сурталчилж аялан тоглолт, хуралд оролцжээ.

Угсаатны хөгжмийн концерт, ОХУ-ын Санкт Петербург хот

ШУА-д их туульч С.Чойсүрэнгийн 100-н жилийн ойн нээлт, зохион байгуулалтын бүх арга хэмжээг ШУА-ын хэл зохиолын хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлжээ.

Үндэсний дуу бүжгийн эрдэмийн чуулгын 30 гаруй уран бүтээлчдэд модон цуур хөгжмийн шавь сургалт явуулжээ.

Угсаатны урлагийн дэлхийн хэмжээний том шагнал “Дэлхийн Маэстро” цол,

Дэлхийн угсаатны ордны эртний хөгжмийн шагналыг хүртжээ

Курилын арал, Индиан, Аляск, Якут, Сибирийн нүүдэлчдийн “Бараган” хурал симпозиум

Э.БААТАРЖАВЫН 2011 ОНООС ХОЙШ ХИЙСЭН ГОЛ АЖЛУУД

(тухайн жилийн 1-3 чухал арга хэмжээг товчлон оруулав)

2011 “Хөгсүү” чуулга, “Аса” цирктэй хамтарсан “Монгол гайхамшиг” тоглолтын нээлт (АЖ Р.Самжид, МУГЖ Х.Чапаевын хамт)

2012 “Хөгсүү” чуулгын бүрэлдэхүүнд ЗХЖШ-тай хамтарч цэрэг эх оронч хүмүүжилд нэмэр хандиваа оруулж дотоодын цэргийн 15 анги нэгтгэлд ардын урлаг соёлын тоглолт лекц хийжээ.

“Хөгсүү” чуулгын бүрэлдэхүүнд дундад Азийн орнуудаар 3 сарын тоглолт хийсний дотор Монгол улс Казахстан улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 10 жилийн ойн концерт, Халимагийн төв театр, Шатарын хотхон зэрэг чухал газруудад Монгол урлаг, соёлоо сурталчилжээ.

Монгол туургатны эрдэмтэд, соёлын зүтгэлтнүүд, шашины төлөөллүүдтэй хамтран “Чингис” уулын тахилгын нээлт

“Хөгсүү” чуулгын бүрэлдэхүүнд Европ тив болон Америк, Скандинавын орнууд, ОХУ, зэрэг олон улсын уран бүтээлчид оролцдог, 30000 үзэгчтэй “**Суломино**” фестивальд амжилттай оролцож, “**Гран при**” шагналийг хүртэж язгуур Монгол соёлоо сурталчилжээ

Монгол туульс засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд зохиогдсон “Монгол туульчдын урын сан” улсын уралдаанд амжилттай оролцож Диплом, мөнгөн шагналаар шагнуулжээ.

Францын 20 хот, Швейцарт “Гималай, Алтайн нуруу, Сибирийн ард түмнүүдийн уугуул соёл” урлагийн тайлан тоглолт арга хэмжээнүүдэд амжилттай оролцжээ.

Аризонагийн олон үндэстний зан үйлийн наадам

2013 ОХУ-ын урлагийн гавьат зүтгэлтэн, хөдөлмөрийн баатар Петер Тимофеевичтэй хамтарч тогложээ.

Улаанбаатар хотод “**Халимаг, Монголын оюуны болон эдийн соёл**” арга хэмжээнд оролцож, зохион байгуулалтыг нь хийжээ.

АНУ-гийн Ласбегас хотод олон улсын бөө мөргөлийн хуралд **“Алтан нуур”, “Атай таван тэнгэр”** аялгуу нь эгшиглэжээ.

1400 гаруй жилийн өмни **“Чүрэ”** хэмээгч туульчийн хадны оршуулгаас олдсон Алтай ятга хөгжмийг сэргээн нутагшуулах ажилд оролцож энэ хөгжим дээр **“Бужин даваа хаан”, “Бөх Алтан нудар”, “Хаан цэцэн зурхайч”, “Талын хар бодон”** туульсаа хайлснаас гадна **“Бөртэ”** хамтлагийн ахлагч хөгжмийн зохиолч Ганпүрэв, Бодонгууд Дөш хоёрын зохиосон **“Дайны бурхан”** бэсрэг туулийг Алтай хамтлагтай хамтарч хайлжээ.

АНУ-ын Веслианы их сургууль, Харвардын их сургуульд уригдан тоглож өв соёлоо хүргэсэн байна.

Стайнфорд, Берклейгийн их сургуульд Монголын урлагийн мастеруудтай тоглосон **“Монголын дуу хоолой”** тоглолтын нээлт, ЭШ-ны хуралд оролцжээ.

2014 Якутын соёлын сайдын урилгаар Монголын хөгжмийн товчоон, Алтай хамтлагийн хамт нүүдэлчдийн фестивалд оролцож тэргүүн байрыг нь хамтлагаарай авч, Нюрбай, Хангалас, Якутск хотуудаар амжилттай тогложээ.

2015 “Тэнгэрийн алтан үг” туулийг гар бичмэлээр хуучин язгуур эхээр нь холбогдох нөхдийн хамт буулгаж байна.

АНУ-ын Хавайн урлагийн хүрээлэнд дуу хуураа хүргэжээ.

БСШУЯ-ны харьяа Соёлын өвийн төвөөс онд Э.Баатаржавын хайльсан арван гаруй туульсаас **“Алтай уулын магтаал”** болон Баян цагаан өвгөн, Зул Алдар хаан, Хаан Чингэл, Хүдэр мөнгөн тэвни туульсуудыг хамтран эмхэтгэж **“Баян-Алтайн гуч Баатаржавын хайлсан туульс”** номыг хэвлэж олны хүртээл, судлаачдын гарын авлага болж байна. Сүүлийн 3 жил хэрэгжсэн Монгол туульс хөтөлбөрийн хүрээнд шавь сургалтыг үе шаттай явуулж, ирээдүйтэй шавь нарыг бэлдэж байна. Хот хөдөөгийн шавь нарыг товшуур хөгжимтэй туульс хайлуулж сургахаас гадна Алтай хамтлагийн уран бүтээлчдэд Алтай ятга хөгжимтэй сургалтыг эхлүүлж байна.

2016 “Дэлхийг тойрох Монгол өв соёл” тоглолтыг санаачилж, Ази, Европ, Америк тивийн 40 гаруй хотод амжилттай тоглов. Мөн энэ тоглолтын хүрээнд дэлхийн хэмжээний хөгжмийн болон дуу, бүжгийн Европ, Америкийн олон чухал фестиваль, наадам тоглолтонд **“Язгуур аялгуу”** хамтлагаараа оролцсоныг доор товчлон орууллаа.

1. Сангисляны олон улсын хөгжмийн наадмын **тэргүүн шагнал** 2016 он
2. Францын Реймсын хөгжмийн наадмын **цом**
3. Дэлхийн олон сая үзэгчтэй СИБ телевизын рекламанд тоглох эрх, шагналын хамт
4. **“Шидэт хөндийн наадам”-ын тэргүүн цом**
5. Францад зохиогдсон олон улсын **“Зуны фестиваль”-ын тэргүүн шагнал**
6. АНУ-ын Юта мужын амбан захирагчын хүндэт жуух (ОУ-ын соёлын арга хэмжээнд)
7. Дэлхийн ардын урлагийн 30-р наадмын **“Шилдэгийн шилдэг”** Гранпри шагнал
8. Дэлхийн хөөмийн холбооноос **“Оны шилдэг хөөмийч”**

2017 “Дэлхийг тойрох Монгол өв соёл” тоглолтын хүрээнд эх орондоо болон Өмнөд болон Латин Америк, Карибын тэнгисийн орнууд, Америкийн хэд хэдэн муж, Канадад зохион байгуулсан зарим чухал тоглолтуудыг товчлон орууллаа

1. Хойд Америкийн дэлхийд нэн ховордсон Инуйт дуучид Чарлоть, Пициулук нартай хамтарсан тоглолт хийж, баримтат кинонд оролцжээ.
2. Канад улсын 150 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан соёлын арга хэмжээнүүдэд оролцож Монреэль, Торонто, нийслэл Оттавагийн үзэгчдэд өв соёлоо сурталчлан хүргэжээ.

3. Нью-Йоркийн Азийн соёлын хурал, Нью-Йорк хотноо болсон Монгол туургатны олон үндэстний соёлын хурал, фестивальд зохион байгуулагчаар оролцжээ.
4. Мөн тус хотын урлагийн зөвлөл, Бруклины засгийн ордонд зохиогдсон соёлын арга хэмжээнүүдэд оролцож, Монгол өвийн сан байгууллагатай хамтран ЮНЕСКО-д бүртгэлтэй өв соёлыг сурталчлах хөтөлбөр боловсруулж, Рузвелт арал дээр **“Эргил Түргил”** туульсаа хайлжээ.
5. Пуэрто-Рикогийн угсаатны урлагийн Контемпорери музей болон Карибын тэнгисийн орнуудад болдог “The wonder of our earth”-д оролцож, Доминиканд болсон олон улсын эртний хөгжмийн наадмаас хүмүүнлэгийн соёлын үнэт зүйл бүтээгчдэд олгодог **“Юниберсаль инк реконосименто”** шагнал хүртжээ.
6. Нийт нүүдэлчдийн туульчдын хүрээнд зохион байгуулагдсан “Жангарын өв тээгчид” туульсын цуврал баримтат кинонд МҮОНРТВ-тэй хамтарч оролцжээ.
8. Монгол төрийн түүхийн музейд туульч Э.Баатаржавын “Тэнгэрийн алтан үг” туульсын үзэсгэлэн анх удаагаа нээгджээ.

Төрийн ордонд туульсаа хайлж, аялгуу эгшгээ хүргэв. Өвлийн сүүл сард туульсаа орон нутагт үе шаттай хайлжээ. ОХУ-ын ардын жүжигчин, нэрт киноны од ойн урианхан Максим Мунзукын сан, Тувагийн Соёлын урлагийн их сургуульд тоглосноос гадна Үндэсний төв музей, Хүмүүнлэгийн академи, Сергей Шойгугийн урлан үзэсгэлэн, Соёлын газар, Сүбээдэй судлалын төвтэй хамтран ажиллажээ.

Мөн угсаатны хөгжим, туульсын мартагдсан хуучин үг хэллэг, ЮНЕСКО-ын сав шим ертөнцийн танин мэдэхүйн уламжлалт ёс зүйг судлах зорилтод үндэслэн хээрийн судалгааны ажлаар 2017-2020 он хүртэл “Хоо Живэртийн нашрын жимээр” сэдэвт Ховд, Увс, Баян-Өлгий, Хөвсгөл, Шиньжаан Уйгарын Алтай, Ховог сайр аймаг, Үрэмч хот, Казакстаны Алмата, Павлодарь, Талдыкурбан, Көкшэтай, Алатауд, Киргизийн Исихкуль, Ош, Чолпоната, Каргайт, уулын Алтайн БНУ-ын Горно-Алтайск, Онгудай, Чоко дама, Тувагийн Хаадын хөндийн дурсгалт газар ажиллажээ./Цаашид жил бүр 6-9 сард хийгдэх юм./

2018 Дас Ихэр сан байгууллагатай хамтран Жангар туульс болон Монгол туульсыг судлах

чиглэлээр хамтран ажиллах үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан.

2018 Биет бус соёлын өвийн наадмаар засгийн газрын шагнал “Соёлын биет бус өвийг олон улс, дэлхийд хамгийн их сурталчлан таниулсан өвлөн уламжлагч” анхны тэргүүн шагналын эзэн болжээ.

Мөн Киргиз улсад болсон Дэлхийн нүүдэлчдийн 3-р наадамд амжилттай оролцож хуучин заншлынхаа дагуу соёлоо сурталчилж, шилдэг өвлөн уламжлагчын шагнал хүртжээ.

“Дэлхийн туульс ба Жангарын хурал” олон улсын симпозиумын нээлт (туульсаар)

Өвлөн уламжлагчдын улсын анхдугаар зөвлөлгөөний нээлт (Үзүүлэх тоглолт мастеркласс)

ОХУ-ын соёлын яамнаас Хакасд зохион байгуулсан өдгөө дэлхийд хөөмийн урлаг хамгийн өндөр хөгжсөн 9 орон оролцсон ОУ-ын мэргэжлийн хөөмийчдийн уралдааны **дэд байрын** шагналыг хүртжээ.

2018 оны засгийн газрын шагнал “Оны шилдэг уран бүтээлч”, “Мөнгөн мод” шагналын эзэн болжээ.

2018 Хэлний бодлогын үндэсний зөвлөлд өөрийн хайлдаг 10 гаруй туульсыг Монгол туульсын

цуврал номонд хэвлүүлэхээр бичиж боловсруулан өгсөн.

2018 “Сүбээдэйн үр сад”, “Өвөг урианхай” байгууллагыг үндэслэн байгуулав.

2019 онд туульч, цуурч, хөөмийч Э.Баатаржавын олон жилийн нөр их хөдөлмөр бүтээл, ардын язгуур урлаг, өв соёлоо олон нийтэд дэлгэрүүлэн таниулах, олон улсад сурталчлахад оруулсан хувь нэмэр болон тив дэлхийн хэмжээний наадмуудын амжилтуудыг нь үнэлж Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигаар **“Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн”** хэмээх төрийн дээд цол, тэмдгээр шагнажээ. Казакстаны **Нурсултан** хотод Назырбаевын нэрэмжит ордонд тэндхийн дипломат корпусынханд тоглов.

“Азийн урлагийн” “наадам, Алтай ятгын орон нутаг дахь сургалтанд зөвлөх багшаар ажиллав. 9 сард Британы **“Стоун хенж”**, **Кембрижийн их** сургуульд тоглов. Киргизэд болсон нүүдэлчдийн шашин, зан үйлийн хуралд оролцов. Их таван Алтайн сав шимийн зан, заншилтай холбоотой соёлын арга хэмжээнд оролцов.

2019 МУ-ын ГХЯ-наас “Монгол улсын соёлын элч” хэмээх эрхэм хүндэт цолыг хүртэж, соёлын консулын статуст томилогдов.

2019 Туульч Э.Баатаржавын хайлсан Жангар Гэсэрийн бүлгүүд номыг МҮОНРТ-н соёл урлагийн редакциятай хамтран эмхэтгэжээ

2020 онд

Монгол улсын ЗГ-аас батлагддаг Монгол Марк цувралд 7 алдартай өвлөн уламжлагчдын хамт бүтээл нь тавигджээ. Мөн Монголын үндэстний уран зохиолын гурван оргилуудын хоёр нь болох **“Гэсэр”**, **“Жангар”** туульсын арав гаруй бүлгийг МҮОНТВ-ын Алтан сан, соёл урлагийн редакцын урилгаар 2 жил гаруй дамнуулан хайлж ном бүтээл болж хэвлэгджээ. Хөл хорионы жил Монгол орныхоо олон уул усанд очиж байгаль сав шим орны зан үйлээ хийж ирлээ. Мөн Жаргалант хайрхны Өмнөхийн амны олдвор болох Алтай ятгыг нутагшуулах ажилд гуравдах жилдээ амжилттай яваад ирж байна.

2020 оны 4 сард Дорнод аймагт Их хар сүлдний тахилгын зан үйлийг сэргээх ёслолд оролцсон.

2020 оны 4 сард Монгол төрийн туульс **“Мөнх сайхан төрт Алтан Торц”** туулийг эзэн Чингисийн төрсөн нутаг Хэнтий аймагт хайльсан.

2020 оны сард Бурхан Халдун уулын тайлгад Монгол бөөгийн **“Тэнгэр”** төвийнхөнтэй хамт оролцсон.

2020 оны 6 сард Ази Европ тивд тэмээн аялалыг зохион байгуулж байгаа Байгальмаатай хамтран **“Монгол давалгаа”** соёлын контент бүтээх аяныг Өмнөговь аймгийн сумдаар зохион байгуулахад хамтарч оролцлоо.

2020 оны 8 сард Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын газрын **“Далай ээж”** компани, Өвөг урианхай холбоо, Чандмань-Эрдэнэ сумын засаг даргын ТГ-тай хамтран Өрлөг Зэлмэ уул, Алангуай хатны цогцолборт Ариг урианхайн өв соёл ЭШ-ны хурлыг 3 хоног зохион байгуулсан.

2020 оны 9 сард Хэрлэн гол, Хордил Сардиг, Дархадын хотгорын байгалийн цогцолборт газарт **“Монгол Давалгаа”** соёлын арга хэмжээний хүрээнд өв соёлын дүрс бичлэг, шингээлтийн ажлыг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

2020 оны 10 сард Юнескогийн Байгаль сав ертөнцийн тухай мэдлэг заншлууд хэмээх категорын заалт, Уулс овоо тахих зан үйлийн хүрээнд Монгол хөгжмийн товчоон, Археологийн хүрээлэн, Алтай хамтлагийн хамт Алтай ятгын 3-дах тахилга мөн уг ятгыг орон нутагт нутагшуулах сургалтыг хийж ирсэн.

2020 оны 11-12 сард ард түмний соён гэгээрэлд зориулж Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран Монгол ардын баатарлаг үлгэр цувралын хүрээнд өөрийн өв урын сангаас хуучны болон дундад эртний гаралтай 25 үлгэрийг бичиж буулгаад байна.

2021 оны 9 сард Юнескогийн Байгаль сав ертөнцийн тухай мэдлэг заншлууд хэмээх категорын заалт, Уулс овоо тахих зан үйлийн хүрээнд **“Хутагт хувилгаат сан”** байгууллагатай хамтарч Халх голын Бурхантын хөндий, Буйр нуурын сав газар хоёр үндсэн тахилгыг хийлээ.

2021 оны 8 сард **“Сутай”** уулын төрийн тахилгад уригдаж, **“Баян цагаан өвгөн”** туульсаа хайлж Алтайн арван гурван овооны тахилгыг бүтнээр хийв.

2021 “Эртний туульсад нэр нь дурдагддаг газар орноор хээрийн судалгаа, зан үйл”-ийн ажлыг 6 сараас 10 сар хүртэл 4 үе шаттайгаар 3 сар хийж нийт 11700км замыг туулж ирсэн байна.

2021 Азийн энэ оны шилдэг бүтээн байгуулалтаар шалгарсан “Мөсөн өргөөний нээлт”-ийг баатарлаг туульсаа хайлж нээв.

2021 Э.Баатаржавын дээд өвөг Баян-Алтайн туульчдын Алтан сүмэлж ёсны болон дундад эртний туульсаас монгол төрийн ордонд залагджээ.

2021 Монгол бахархлын өдрөөр “Аргил цагаан өвгөн” туульсыг төрийн гурван өндөрлөгийн тэргүүн болон албаны бусад хүмүүст бүтнээр хайлав.

2022 Жангарын “Авланга хаан”, “Далан хааны бөлөг”-ийг МҮОНРТВ-тэй хамтран Ховд, Говь-Алтай аймгийн нутагт хайлж бичүүлэн, твитер зүүлтийн хамт дүрсжүүлэн олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн байна.

2022 “Наран хаан” хөвүүн туульсыг Монгол төрийн ордонд хайлав.

2022 “Монгол шуудан” компани, “Их монголын хутагт хувилгаад сан” байгууллагуудтай хамтран “Галдан хаан”-ы маркийн нээлт, мөн Өөлдийн таван шүтээний тахилга, арван гурван санд хамтарч оролцожээ.

2022 “Монгол туулийн үечлэл” сэдвээр (ph)докторын зэрэг хамгаалсан.

2022 Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн Монгол төрийн наадмын нээлтийг хийсэн.

2022 Улаанбаатарын “Нүүдэлчин” олон улсын наадмын ерөнхий зөвлөхөөр ажиллав.

2022 Дэлхийн шилдэг “National geography”, “Discovery” зэрэг дэлхийн 7 продакшины Монголд хийсэн айлчлалд оролцож тоглов.

2022 Ховд хотод зохиогдсон “Цайны зам” наадамд ерөнхий шүүгчээр ажиллаа.

2022. Чингэлтэй хайрханы тахилгыг “Язгууртан Монгол” байгууллагатай хамтарч хийв. (10 сар

2022. МҮОНТВ тэй хамтран “Туульсын зам” цуврал нэвтрүүлгийн орон нутагт хийсэн дугаарт ажиллав

(10 сар)

2022. 12 сар Энэтхэгийн Дели хотод болсон олон улсын туулийн хуралд хувиараа зардлаа зохицуулж улсаа төлөөлж амжилттай оролцож, “Махабхарита” туульсын судлаачидтай харилцаа тогтоож, хамтран туршлага солилцож ирсэн.

2022 Сингапур улсад өв соёлоо сурталчлан таниулсан.

2022 оны 12 сард төв Азийн туулийн симпозиумд “Аваргасын орны өвөг туульс” сэдвээр илтгэл тавьж, концертыг нь МУГЖ Энхгэрэлтэй хамтран найруулсан.

2023 он. Энэтхэг улсын Дели хотод болсон олон улсын туульсийн хуралд эх орноо төлөөлөн амжилттай оролцож, хувийн зардлаа зохицуулж, судлаачидтай харилцаа тогтоосон “Махабхарита” туульс, хамтдаа туршлагаа хуваалцсан. 2023 Сингапурт өв соёлоо сурталчилсан

- “Мөнх сайхан төрт Алтан Торц баатар” туулийн Долоон Бурхантын бүлэгийн зураг авалт бүтэн бичлэг/Хэнтий аймгийн Биндэр, Мөнгөнморьт, Цэнхэрмандал сумуудад МҮОНРТ-ын соёл урлагийн редакцын хамт
- /Говь-Алтай аймагт зохион байгуулагдсан МУСГЗ Э.Баатаржавын нэрэмжит туульс хайлах уралдаан
- Галдан Бошгот хааны онгон шүтээний тайлга тахилгын ерөнхий найруулагч
- Говь-Алтай аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн нээлтийн арга хэмжээнд монгол туургатны туульчдын хамт тууль хайлсан.
- Дэлхийн монголч эрдэмтдийн 12-р их хуралд төлөөлөгчөөр уригдаж илтгэл тавьсан
- ОХУ
- МУ-ын ЕТГ-аас зохион байгуулсан Таван Богд уулын тахилгын ЭШХ-д Алтай магтаал сэдвээр илтгэл тавьсан.
- “Нью-Йорк хотод хийх соёлын ажлын багийн гишүүдтэй хийх онлайн уулзалт”(Тус хотод тоглолтыг хамтран зохион байгуулах албан байгууллага, хамт олон хувь

хүмүүстэй онлайн уулзалтыг хийж, техникийн зөвлөлгөөнийг хийсэн).2023 оны 4 сарын 5.Нью-Йорк хот. Манхатен дүүрэг

- “Цагийн шалгуурыг туулсан Монгол өв соёл” нэртэй тоглолт НҮБ-ын суурин төлөөлөгчийн газарт. . 2023.4.07
- “Explorers Club” ротари Клубын ОУ-ын хурал 2023.4.22
- Нэрт сэтгүүлч , продюссер Эйлиний эрхлэн гаргадаг цахим сэтгүүлийн “Heritage” буланд ярилцлага өгсөн 2023.4.23
- “Төв Азийн эртний хөгжим” лекц тоглолт 2023.4.24
- “Монгол язгуур” концерт 2023.4.26
- Дэлхийн марафон гүйлтийн холын зайн үнэмлэхүй аварга”-ын тэмцээний сурталчилгаанд хөөмий, цуур, хэл хуур, бит боксын төрөл, чиглэлээр сурталчлан оролцов. 2023.4.17-27
- “Jew harp with beatbox”хөгжмийн импровизаци 2023.5.03
- Монгол язгуур” урлагийн тоглолт, студын бичлэг 2023.5.03
- Олон улсын хүрээлэн байгаль орчны “Shale Network Workshop” чуулганд уригдан оролцож, албан ёсны нээлтэнд тууль хайлж, дудар чашгын зан үйлийг сурталчилж оролцов. 2023.5.03
- Nigara falls Ethnic day Фенсилвани мужийн хил залгай орших Ниагаригийн хүрхрээн-ий орчмын газар нутагт энэ удаа очиж, өв соёлын зан үйл хийлээ. Мөн угтал тууль болох “Алтайн магтаал”-ыг бүрэн эхээр нь хайллаа. 2023.5.21
- Вашингтон хотын түүхэн дурсгалт газруудаар тоглож, Монгол үндэсний дээл хувцсаа сурталчилж тайлбарлах, “Монгол ёс заншлаа сурталчлах өдөрлөг”-ийг “Mer” байгууллагыг үүсгэн байгуулагч Урнаагийн хамт зохион байгуулав.
- Монгол өв” лекц, тоглолт, асуулт хариулт гэсэн гурван үе шаттай өдөрлөгийн түвшинд зохион байгуулсан. “Гроу Монголия” Вашингтон 2023.5.25-27
- **Вашингтон** хотын төвийн дүүргүүдэд **“Монгол үндэсний хувцас сурталчлах , дугаралтын техник үзүүлэх өдөрлөг”**-ийг зохион байгуулав.Уг өдөрлөгийг тэнд оршин суугч Г.Урнаатай хамтран зохион байгуулсан. 2023.5.27
- Америкийн соёл спортын мэдээлэлийн “Ньюсь” сувагт монгол хөөмийн тухай товч яриа өглөө. 2023.5.27
- Будапешт хотын хөгжим судлаачид, соёлын зүтгэлтнүүд, залууст тоглосон баярын концертын нээлтэнд монгол ардын хөгжмийн зэмсгийн “мастер класс” үзүүллээ.2023.6.11.
- Будапешт хотын хотын эзэн хааны ордны дотор задгай талбайд болсон тоглолтонд **Америк, Гүрж-ийн уран бүтээлчдийн хамт тоглож оролцлоо. 2023.6.13**
- Будапешт хотын **“Баатруудын талбай”**-д болсон шоуны нээлтийн тоглолтонд тоглолоо.**2023.6.14 Будапешт**
- **Дунай Карнавал**-ын хүрээнд улсын төв музейд болсон тоглолтонд цуур тоглож, ардын хөгжимчин **П.Болормаа** дудар, чашга хөгжмийг хоршиж тоглосон **“Хэлхээ аялгуу”** эгшиглүүлээ 2023.6. 17 **Будапешт**
- **“Унгар улсын төрийн сүлдний 200 жил”**-ийн арга хэмжээний хүндэтгэлийн тоглолтонд тус улсын үндэсний дуу бүжгийн чуулгын дуучид, магтаалч бүжигчдийн хамт нээлтийн арга хэмжээнд оролцов 2023.6. 18 **Будапешт**

Унгар улсад зохион байгуулагдсан **“Дунай Карнавал”, “Унгар улсын төрийн сүлдний ой”** арга хэмжээнүүд 8 хоног үргэлжилж Монгол улсын уран бүтээлч, өвлөн уламжлагч бид **“Чэйн Бридж”** шагналыг олон улсын уран бүтээлчдийн өмнө ёслол төгөлдөр гардан авлаа. 2023.6. 19 БудапештЭ.Баатаржавын 2024 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тойм

2024 оны 1 дүгээр сар

- **“Дэлхийд тархсан монгол өв соёл”** сэдэвт эрдэм шинжилгээний хуралд оролцов. Чингис хааны музейд зохион байгуулагдсан уг хуралд **“Чингис хааны тухай таван дууны учир”** сэдэвт илтгэл тавьж, Чингис хааны үеэс уламжилсан аман өвийн ховордлын асуудлаар санал бодлоо солилцов.

- ОХУ-ын Элчин сайдын МУЭИС-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Эрдмийн Их Сургуулийн Ельцины танхимд болсон хамтын ажиллагааны хуралд оролцож, Ельцины нэрэмжит номын санд төрийн ёсны туульсаас хайлж, соёлын танилцуулга хийв.
- Улаанбаатар хотод МУСГЗ хөгжим урлаач Байгальжавтай хамтран “Монгол цуур” цахим сургалтыг албан ёсоор эхлүүлэв. Мөн “Хүннү фэйшн”-тэй хамтран цахим сургалтын программ боловсруулж, 80 гаруй цуур хөгжим үйлдвэрлэн сургалт, өвлөн уламжлалд ашиглалтад оруулав.

2024 оны 2 дугаар сар

- Ховд аймгийн ЗДТГ-тай хамтран “Жангар” туулийг бүрэн эхээр нь хайлж, нутгийн 270 гаруй иргэн хамрагдсан соёлын арга хэмжээг зохион байгуулав.
- МҮОНРТ-д зориулан “Монгол ардын баатарлаг туульс” сэдэвт 11 ангит нэвтрүүлэг бэлтгэж, цагаан сарын өмнө цувралаар нэвтрүүлэв. Уг төслийн хүрээнд өвөл, зуны улиралд бүтэн жилийн турш зураг авалт хийсэн.

2024 оны 3 дугаар сар

- Нийслэлийн гурван дүүрэгт “Алтан өв” соёл гэгээрлийн ажлыг 3 үе шаттайгаар зохион байгууллаа. Шадар сайд С.Амарсайханы дэмжлэгтэйгээр “Монгол ёс уламжлал” сэдвийг олон нийтэд таниулж, Налайх дүүргийн 400 гаруй иргэн хамрагдав.
- Чингис хааны музейд, Ерөнхийлөгчийн Тамгын Газрын дэмжлэгтэйгээр “Зургаан түмэн настай Зул Алдар хаан” туулийг бүрэн эхээр нь хайлж, 180 гаруй үзэгч оролцсон арга хэмжээг зохион байгуулав.

2024 оны 4–5 дугаар сар

- Австрали улсын Сиднейн их сургууль, Камбера хотын соёлын байгууллагуудтай хамтран ажиллав. Цуур тоглолт, судалгааны илтгэл тавьж, Австрали тивийн уугуул иргэдтэй хамтарсан соёлын арга хэмжээнд оролцов. Олон улсын эртний хөгжмийн наадамд амжилттай оролцож, 750–800 үзэгч хамрагдав.
- Ховд аймгийн Дуут суманд “Аргиль цагаан өвгөн” туулийг хайлж, 430 гаруй иргэн оролцсон.

2024 оны 7 дугаар сар

- Үндэсний их баяр наадмын нээлтэд оролцож, 26 хоногийн нэгдсэн бэлтгэлд хамрагдан, улс даяар цацагдсан нээлтийн үйл ажиллагаанд оролцов.
- “Алаг сүлдний тахилга”-ыг “Тайгам Алтай” групптэй хамтран 4 үе шаттайгаар зохион байгуулж, 600 гаруй хүн оролцов.
- “Монгол Алтайн өв соёл” арга хэмжээг “Покит трабел” ХХК-тай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 100 гаруй хүн хамрагдав.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газрын хүрээнд Бурхан Буудай, Таван богд, Суварга хайрхны тахилга-д зан үйл, ёс уламжлалын зөвлөгч, тахилч туульчийн үүрэг гүйцэтгэв.

2024 оны 7–8 дугаар сар

- **Галдан бошигт хаан мэндэлсний 380 жилийн ойд** зориулсан нээлтийн зан үйлийг Ховд аймагт гүйцэтгэж, аймгийн бүх сумаас ирсэн иргэд оролцов.

2024 оны 9 дүгээр сар

- **“Туульд гардаг газар усны нэрсийн хээрийн судалгаа”-г** зохион байгуулж, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий аймгийн нутгийг хамруулан судалгааг гүйцэтгэсэн.

2024 оны 10 дугаар сар

- Увс аймагт нэрт туульч Парчин гуайн хайлдаг **“Бум эрдэнэ” туулийг** сэргээн хайлж, уг туулийн өдөрлөгийг зохион байгуулсан. **10 гаруй жилийн судалгаа, бэлтгэлийн үр дүн бөгөөд 300 гаруй хүн** оролцов.

2024 оны 11 дүгээр сар

- **Жангарын олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Алтай хэлт ард түмний эртний соёлын онцлог”** сэдэвт судалгааны илтгэл тавьж, хэлэлцүүлэгт оролцов.

2024 оны 12 дугаар сараас 2025 оны 1 дүгээр сар

- Африк тивийн **9 улсаар 40 гаруй хоног** аялан тоглож, Масая омгийнхон, Мадагаскарын хөгжмийн продюсер Катрина Хэйнз зэрэгтэй хамтран зан үйл, тоглолт, соёлын арга хэмжээг зохион байгуулав. Мөн Грек, Египет, Швейцар улсад соёлын хөтөлбөр хэрэгжүүлж, **7000 гаруй хүнд монгол өв соёлыг сурталчилсан** бөгөөд **Африкийн соёлын байгууллагын шагналаар шагнагдсан.**

2024 оны дээрх үйл ажиллагаанд:

Нэг арга хэмжээнд **100–3000 хүн** оролцсон бөгөөд давхардсан тоогоор **дотоод, гадаадын 50,000 гаруй хүн** үзэж, сонирхож, хамрагдсан байна.

Мөн: Долоо хоног бүр дэлхийн өнцөг булан бүрт буй монголчууд, Улаанбаатар хот болон орон нутгийн шавь нартаа **тууль, цуур, хөөмийн тогтмол сургалтыг** тасралтгүй явуулж байна.

2025 онд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, урлаг, уламжлал, сургалтын ажлын нэгдсэн жагсаалт

1. **2025.01 сар** – “Дэлхийг тойрох Монгол өв соёл – V” аялан тоглолтыг Хонконг, Сингапур, Австрали, Африкийн 9 улс, Швейцар, Грек, Египет зэрэг орнуудад зохион байгуулж, монгол туулийн айзамт хайллага, уламжлалт зан үйл, танин мэдэхүйн лекцийг танилцуулсан. Нийт 3000 гаруй үзэгч хамрагдсан.

(Чиглэл: Урлаг, соёлын дипломат)

2. **2025.01.07, УБ** – “Эртний монгол хийц” загварын шоуны нээлтэд “Баян цагаан өвгөн” туулийг хайлж, 300 орчим үзэгчид толилуулав.

(Чиглэл: Урлаг)

3. **2025.01.23, УБ** – “Онгод шүтээн, Монгол туульсын шүтэлцээ” сэдэвт танин мэдэхүйн өдөрлөгийг Бат-Өлзийтэй хамтран зохион байгуулж, 200 гаруй оролцогч хамрагдав.

(Чиглэл: Сургалт, уламжлал)

4. **2025.02.01, УБ** – МҮОНРТ-ээр цацагдсан Жангар туулийн нэвтрүүлэгт оролцож, Хүн театр, Дас ихэр сан, МҮОНРТ-тэй хамтран уламжлалт туулийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлав.

(Чиглэл: Урлаг, олон нийт)

5. **2025.02.10, Ховд аймаг, Дуут сум** – “Монгол туульсын язгуур голомт” лекц уншиж, “Зул алдар хаан” туулийг бүрэн хайлж, 400 орчим оролцогч хамрагдав.

(Чиглэл: Урлаг, түүх)

6. **2025.03.02, УБ** – Чингис хааны музейн алтан хөшөөний нээлтийн ёслолд “Мөнх сайхан төрт алтанторц” туулийг хайлж, 500 гаруй оролцогчтой төрийн арга хэмжээнд оролцов.

(Чиглэл: Урлаг, төрийн ёслол)

7. **2025.04.01–10, Дархан, Орхон, Хөвсгөл** – Сүбээдэй жанжны мэндэлсний 850 жилийн ойд зориулсан лекц, тоглолтыг зохион байгуулж, 1000 орчим оролцогч хамрагдав.

(Чиглэл: Эрдэм шинжилгээ, урлаг)

8. **2025.04.25, Узбекистан** – Олон улсын “Багши туулийн наадам”-д Монгол Улсыг төлөөлөн ОУ-ын шүүгчээр ажиллав. Шилдэг сайн ажилласан шүүгчдийн тоонд багтаж диплом, баярын бичгээр шагнуулав.

(Чиглэл: Олон улсын соёлын төлөөлөл)

9. **2025.04 сар, Киргизстан** – Олон улсын туулийн бага хуралд “Эртний монгол тууль”-ийн бүтэц” сэдвээр илтгэл тавив (150 орчим оролцогч).

(Чиглэл: Эрдэм шинжилгээ)

10. **2025.04.5 УБ** – Мандал сантай хамтран “Зул алдар хаан” туулийн бүтэн хайллагыг зохион байгуулж, 300 орчим үзэгч хамрагдав.

(Чиглэл: Урлаг)

11. АНУ-ын Нью-Орк, Санфранциско хотуудад өвөө сурталчилж ирсэн.

2025.04.8-25

12. **2025.05.06, Дундговь** – “Монгол туулийн зан үйл” өдөрлөг зохион байгуулж, зан үйлийн үзүүлбэр, бүтэн хайллагыг 250 орчим хүнд хүргэв.
(Чиглэл: Уламжлал)

13. **2025.05.22, Сүхбаатар** – МУАЖ Ш.Чимэдцэеэгийн эрдэм шинжилгээний хуралд “Уртын дуу–тууль”-ийн уялдаа холбоо” сэдвээр илтгэл тавив (200 оролцогч).
(Чиглэл: Эрдэм шинжилгээ)

14. **2025.05.25, Ховд аймаг, Манхан сум** – “Алтай ятгын тахилга” зан үйлийг гүйцэтгэж, 300 орчим хүнийг хамруулсан уламжлалт арга хэмжээ зохион байгуулав.
(Чиглэл: Уламжлал)

15. **2025.05.29, УБ** – Улсын Их Хуралд болсон “Монгол өв уламжлал” арга хэмжээнд лекц уншиж, концертын хөтлөлт хийв (400 оролцогч).
(Чиглэл: Урлаг, олон нийт)

16. **2025.06.12, КУДС** – Урлагийн менежментийн чиглэлээр эрдмийн ажил хамгаалж, магистрын зэрэг хамгаалав.
(Чиглэл: Эрдэм шинжилгээ)

17. **2025.07.21, Увс аймаг** – Аймгийн 100 жилийн ойд зориулан “Бум эрдэнэ” туулийг бүрэн хайлж, 1000 гаруй үзэгч хамрагдав.
(Чиглэл: Урлаг)

18. **2025.07.25, УБ** – “Монгол соёлын дипломат” сэдэвт судалгааны ном бичиж дуусгав.
(Чиглэл: Эрдэм шинжилгээ)

19. **2025.08.01, Киргизстан** – Олон улсын нүүдэлчдийн хуралд тууль зүйн судалгааны илтгэл тавив (300 оролцогч).
(Чиглэл: Эрдэм шинжилгээ)

20. **2025.08.11, Ховд** – Соёл, шашны их хуралд “Алтай магтаал” сэдвээр илтгэл тавив (150 оролцогч).
(Чиглэл: Эрдэм шинжилгээ)

21. **2025.08.15, УБ** – Олон улсын санхүүчдийн хуралд “Гал улаан бодон” туулийг бүрэн хайлж, хөтлөгчөөр ажиллав (1000 оролцогч).
(Чиглэл: Урлаг)

22. **2025.09 сар, УБ** – Богд хан уулын улсын тахилгын ёслолд уламжлалт туулийн хайллалт үйлдэв (500 оролцогч).
(Чиглэл: Уламжлал)

23. **2025.09 сар, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай** – Сүбээдэй жанжны ойд зориулсан баруун бүсийн лекц, тоглолтыг зохион байгуулж, 800 орчим оролцогч хамрагдав.
(Чиглэл: Эрдэм шинжилгээ, урлаг)

24. **2025.06–12 сар, УБ. Төрийн тууль болох «Мөнх сайхан төрт АлтанТорц» туулийн бүтэн эхийг соёлын бүтээлч сард зориулан 4 сарын хугацаанд бичиж, хянаж, редакцлан хэвлэлтэд бэлтгэн, ном болгон хэвлүүлэв.**
(Чиглэл: Судалгаа, соёлын өвийн бүтээл)

25. **2025.10.16, Энэтхэг** – “Монгол туулийн цаг хугацааны онцлог” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл олон улсын сэтгүүлд хэвлэгдэв.
(Чиглэл: Эрдэм шинжилгээ)

26. **2025.10 сар, Хэнтий аймаг** – Бурхан Халдун уулын төрийн тахилгын хүрээнд “Алтан Торц” төрийн туулийг хайлав (200 оролцогч).
(Чиглэл: Уламжлал)

27. **2025.11 сар, Дорнод аймаг** – “Агтан хүрээт” наадамд оролцож, алаг сүлд цэнгүүлэх болон тахилгын зан үйл гүйцэтгэв (300 оролцогч).
(Чиглэл: Уламжлал)

28. **2025.11 сар, УБ** – “Есөн туг” эрдэм шинжилгээний хуралд “Чингис хааны үеийн туульс” сэдвээр илтгэл тавив (500 оролцогч).
(Чиглэл: Эрдэм шинжилгээ)

29. **2025.11.23, УБ** – Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Алтай Чингэл” туулийн бүтэн хайллатыг зохион байгуулж, 70 орчим үзэгч хамрагдав.
(Чиглэл: Урлаг)

30. **2025.09.28–11.20** – Улаанбаатар, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймагт шавь сургалт зохион байгуулж, монгол тууль, цуурын сургалт явуулав.
(Чиглэл: Сургалт)

31. **2025 он, УБ** – Магистрын түвшний оюутнуудад соёлын өвийн судлал, өвлөн уламжлуулах зүй тогтол сэдвээр хичээл заав.
(Чиглэл: Эрдэм шинжилгээ, сургалт)

2025 он турш, Говь-Алтай аймаг – 2021 оноос эхлэн 1300 гаруй жангарч хүүхдийг бэлтгэх сургалтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэв.
(Чиглэл: Өвлөн уламжлалт сургалт)

32. **2025 он, УБ** – Консерваторийн Ардын хөгжмийн ангид багшилж, ерөөл, магтаал, морины цол, товшуур, хэл хуур, аман билгийн уялдаа холбооны хичээл заав.
(Чиглэл: Дээд боловсрол)

33. **2025 он, УБ** – Магистрын түвшний оюутнуудад соёлын өвийн судлал, өвлөн уламжлуулах зүй тогтол сэдвээр хичээл заав.
(Чиглэл: Эрдэм шинжилгээ, сургалт)

34. МҮОНРТВ-тэй 12 дахь жилдээ хамтран ажиллаж Жангарын «Догшин Хялган хааны бүлэг»-ээр 7 үзэгдэлт баримтат кино бүтээж сар шинээр үзэгчдэд хүргэхээр монтажны ажил нь өндөрлөж байна.

35. Сүбээдэй баатрын мэндэлсний 850 жилийн ойд зориулж «Сүбээдэй баатарын тухай олон үндэстний домгууд» илтгэлийг сүүлийн 20 гаруй жилд Польш, ОХУ, Казакстан, Шинжаан гэх мэт газруудаас цуглуулсан материалд тулгуурлан бичиж дуусаад уг баатрын хөргийг бүтээх ажилд зориулж түүхэн сэдвээр хөрөг зурдаг зураач нарын дунд уралдаан зарлан ажиллаж байна.

36. «Монгол ардын аман билгийн үгс» номоо 5 сар гаруй бичээд оны өмнө амжуулж дуусгахаар зорин ажиллаж байна.

37. «Хурд» хамтлагтай хамтран «Монгол өв соёл» аяныг 2026 онд гүйцэтгэхээр бэлтгэл ажлуудаа эхлүүлж байна.

38. Хөгжим Бүжгийн Консерватортай хамтран туульс, хөөмийн чиглэлээр шавь бэлдэх ажлыг 9 сараас эхлэн ажлаад эхний үр дүнд хүрээд явж байна.

2025 оны амжилт, бүтээлүүд:

(2025 онд хийсэн ажлын гол ач холбогдол)

2025 онд Э.Баатаржав нь Монголын аман өв, тэр дундаа **тууль, цуурын уламжлалыг** боловсрол, судалгаа, өвлөн уламжлал, олон улсын сурталчилгааны чиглэлээр **тогтвортой, зорилготойгоор** хэрэгжүүлэв.

Нэгдүгээрт,

Боловсрол, өвлөн уламжлалын чиглэлд

Улаанбаатар хотод магистрын түвшний оюутнуудад соёлын өвийн судлал, өвлөн уламжлуулах зүй тогтлын хичээл зааж, эрдэм шинжилгээний суурь мэдлэгийг түгээн дэлгэрүүлсэн. Мөн 2021 оноос эхэлсэн Говь-Алтай аймаг дахь **1300 гаруй жангарч хүүхдийн сургалтыг** үргэлжлүүлж, бодит өвлөн уламжлагчдыг системтэй бэлтгэх ажлыг тасралтгүй хийсэн. Улаанбаатар, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймагт шавь сургалт зохион байгуулж, монгол тууль, цуурын сургалтаа улам чанаржуулж явуулаа.Одоо мөн онлайнаар тэдэнтэйгээ холбоо хэлхээтэй ажиллаж байна.

Хоёрдугаарт,

Өвийн хадгалалт, материаллаг дэмжлэгийн чиглэлд

Цуурын цахим сургалтыг тогтворжуулж, үйлдвэрлэсэн хөгжмийн зэмсгийг сургалт, музей, өв тээгчдэд хүлээлгэн өгч, аман болон материаллаг өвийн уялдаа холбоог бодитой хангаж ажилласан. МҮОНРТВ-тэй 12 дахь жилдээ хамтран ажиллаж 7 сарын туршид Жангарын «Догшин Хялган хааны бүлэг»-ээр 7 үзэгдэлт баримтат кино бүтээж сар шинээр үзэгчдэд хүргэж байгаа нь үнэхээр тасралтгүй хөдөлмөрлөж байгаагийн нэгэн чухал үзүүлэлт юм.

Гуравдугаарт,

Олон улсын хамтын ажиллагаа, сурталчилгааны чиглэлд

2024 оны сүүлээс 2025 оны эх хүртэл Африк, Европын улс орнуудад хэрэгжүүлсэн өв соёлын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Монголын тууль, зан үйлийг олон улсын соёлын орон зайд таниулсан. Үүний үр дүнд Монголын аман өвийг тив дамнан сурталчилсан тогтвортой харилцаа, хамтын ажиллагааны суурь тавигдсан.Африк, ази, америк тивийн өв соёлын байгууллагаас сайшаагдаж шагналд тодорхойлогдсон.

Дөрөвдүгээрт,

Судалгаа, хөгжлийн чиглэлд

Арктикийн бүс нутгийн уугуул иргэдийн хоолойн дууны судалгааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж, Монголын хөөмий, туулийн айзамт уламжлалтай харьцуулсан судалгааны шинэ чиглэлийг төлөвлөсөн.


Тавдугаарт,

Ирээдүйн бодлого, зорилт

Дэлхийн ардын урлагийн 35-р их наадамд оролцох, туульсын цуврал бүтээл гаргах, соёлын элч нартай хамтран дотоод, гадаадад соёлын арга хэмжээ зохион байгуулах зэрэг ажлыг Монгол Улсын Засгийн газрын **“Алсын хараа–2050”** бодлоготой уялдуулан төлөвлөж, хэрэгжилтийн шатанд оруулсан.

2025 онд хийсэн ажлууд нь нэг удаагийн арга хэмжээ бус, **өвийг амьд хэлбэрээр хадгалах, судлах, заах, түгээн дэлгэрүүлэх** гэсэн цогц зорилгод чиглэсэн, үргэлжлэлтэй, бодит үр дүнтэй үйл ажиллагаа байв.

Төрийн өвөг тууль ном 6 сарын туршид бичигдэж, манай тэргүүлэх эрдэмтэд оршлыг нь бичиж өнгөрсөн 7 хоногт хэвлэлд шилжсэн.Туулийн ховор сайхан өвийг эрдэм шинжилгээ, судалгааны түвшинд бүтээж баринтагласан.





2. Уламжлалыг өвлөн авсан эх сурвалж, залгамж чанар

Монголын Алтайн урианхайн язгуур туульчдын гурван том галд хамаарах өөр өөрсдийн онцлогтой уламжилж ирсэн гэрийн дэг сургуулилалт байдаг. Тэдний нэг нь Хоо Живэртийн удмын тахилч туульчид. Эдгээр туульчдыг дурдвал Баатаржаваас Баян-Алтай хүртэл дөрвөн үе (Баян-Алтай, Живэрлэг, Эрдэнэцогт, Баатаржав), Хоо-Живэртээс Бодноо хүртэл таван үеийн туульчид болох юм (Бодноо, Гилайн-Ээв, Сэнкирай, Буурал-Арван, Хоо Живэрт). Эдгээр туульчид нь туульс хайлахаасаа өмнө цагаан уулаар дамнагч дээд савслага орон, огторгуй тэнгэрт газрын эздийн өмнөөс тахилга өргөдөг. Түүнийг нь «Нашир» хэмээн нэрлэдэг.

Мөн Баруун Монголын туульчид, хөөмэйчид, цуурчдаас багш-шавийн уламжлалаар, аман хэлбэрээр өвлөж, тухайн өвийн жинхэнэ эх сурвалж, хувилбар, хэл найруулгыг алдагдуулахгүй хадгалж ирсэн. Энэ нь Монголын аман уламжлалын тасралтгүй залгамж чанарыг баталгаажуулж буй бодит баримт юм. Монгол туульс хөтөлбөрийн хүрээнд шавь сургалтыг үе шаттай явуулж, ирээдүйтэй шавь нарыг бэлдэж байна.

2015 оноос хот хөдөөгийн шавь нарыг товшуур хөгжимтэй туульс хайлуулж сургахаас гадна Алтай хамтлагийн уран бүтээлчдэд Алтай ятга хөгжимтэй сургалтыг эхлүүлж байна.

2011 онд Үндэсний дуу бүжгийн эрдэмийн чуулгын 30 гаруй уран бүтээлчдэд модон цуур хөгжмийн шавь сургалт явуулжээ.

Цахим сургалт 2024.01 сар Улаанбаатар хот МУСГЗ хөгжим урлаач Байгальжавтай хамтран “Монгол цуур” цахим сургалтаа эхлүүлсэн.

“Хүннү фэйшн”-тэй хамтран цуурын цахим хичээл ийн программ боловсруулж, 80 гаруй цуур хөгжим үйлдвэрлэж, зохион.б хийсэн

Шавь сургалт – Соёлын бүтээлч сар 9/28–11/20 УБ, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд Монгол тууль, цуурын сургалт

2021 оноос зааж буй 1300 жангарч хүүхдийн хичээл 2025 он турш Говь-Алтай аймагт өвлөн уламжлагч хүүхдүүдийг бэлтгэх сургалтаа үргэлжлүүлсэн

60 цуур, 32 товшуур, 5 икэл, 8 дээл хийлгэн музей, өв тээгчдэд хүлээлгэн өгсөн

3. Аман өвийг аварч хадгалсан бодит үр дүн

Эрдэнэцогтын Баатаржав нь Баруун Монголын 30 гаруй бүрэн хэмжээний туулийг амьд хайлалтын аргаар сэргээж, бичлэгжүүлэн хадгалсан нь устаж мөхөх аюулд орсон аман өвийг бодитоор аварсан томоохон хувь нэмэр болсон. Мөн хөөмэй, цуурын 20 гаруй уламжлалыг багш нараас нь өвлөж, баримтжуулснаар залгамж халаа тасрах эрсдэлийг бууруулсан. 60 цуур, 32 товшуур, 5 икэл, 8 дээл хийлгэн музей, өв тээгчдэд хүлээлгэн өгсөн Туульч Баатаржавын хайлсан урианхай болон бусад угсаатан ястны туулиуд (Монголын үндэсний олон нийтийн радио телевиз болон хальсанд DVD, аудио байдлаар бичигдэн үлдсэн туулиуд 1995-2022 он хүртэлх хугацаанд)

1. Алтай уулын магтаал (Баян-Алтай Хоо-Живэртийн хувилбараар олон удаа хайлсан.)
2. Аргил Цагаан Өвгөн (Урианхайн баатарлаг тууль) олон удаа хайлсан “Стар ТВ” бүрэн эхээр нь бичиж дамжуулсан.
3. Баян Цагаан Өвгөн (Урианхайн баатарлаг тууль) олон удаа хайлсан. МҮОНТВ-ээр олон удаа хайлагдсан.
4. Бөх Алтан Нудрам (Урианхайн баатарлаг тууль) олон удаа хайлсан. Мөн “Соён гэгээрүүлэгч” телевизийн захиалгаар хайлав.
5. Бужин Даваа Хаан (Урианхайн баатарлаг тууль) олон удаа хайлсан.
6. Галзуу Хар Хөхөл (Урианхайн баатарлаг тууль) АНУ-ын Лос-Анжелес хотын Холливудын ууланд хайлсан.

7. Талын Хар Бодон (Урианхайн баатарлаг тууль) Азийн бөөгийн холбооны захиалгаар 2007 онд хайлсан.

8. Наран Хаан Хөвүүн (Урианхайн баатарлаг тууль) туульч Б.Уртнасанаас залж, сурсан тууль. Волгоград хотод 2007 онд хайлагдсан. Мөн бусад газруудад хайлагдсан. 2021 онд төрд хайлагдсан

9. Хүдэр Мөнгөн Тэвнэ (Урианхайн баатарлаг тууль) олон удаа хайлсан.

10. Хаан Цэцэн Зурхайч (Урианхайн баатарлаг тууль) “Соён гэгээрүүлэгч” телевизийн захиалгаар хайлав

11. Хүрэл Алтан Дөш (Урианхайн баатарлаг тууль) “Соён гэгээрүүлэгч” телевизийн захиалгаар хайлав

12. Эзэн Улаан Бодон (Урианхайн баатарлаг тууль) “С1 ТВ”-ийн захиалгаар хайлав.

13. Алтайн Хар Торц (Урианхайн баатарлаг тууль) “Соёмбо” телевизийн захиалгаар хайлав.

14. Алтай Чингэл Баатар (Урианхайн баатарлаг тууль) 2008 онд хэвлэгдсэн.

15. Хаан Чингэл Баатар (Урианхайн баатарлаг тууль) 2015 онд хэвлэгдсэн.

16. Мөнх сайхан төрт Алтан Торц Баатар (Урианхайн баатарлаг тууль) ([watch/live/?ref=watch_permalink&v=261806475344820](https://www.youtube.com/watch/live/?ref=watch_permalink&v=261806475344820) Төрийн ордон 2019 он.)

17. Баатар Хар Жандалба (Урианхайн баатарлаг тууль) Хутагт хувилгаад сангийн захиалгаар.

18. Зул Алдар Хаан (Урианхайн баатарлаг тууль) Богд хааны ордон музейд болон бусад газрын урилгаар олон удаа хайлсан.

19. Эрийн сайн Хан Харангуй (Урианхай болон монгол үндэстний баатарлаг тууль). 2014 онд Домникан, Пуэрто Рикод хайлагдаж байсан. Монгол улсын ерөнхийлөгчийн дэргэдэх хэлний бодлогын зөвлөлөөр хэлэлцүүлэгдэн редакторлаж, Төрийн ордонд 2021 онд хэвлэгдэж тавигдсан.

20. Долоон түмэн настай Довон Хар Бөх (Урианхайн баатарлаг тууль) <https://montsame.mn/cn/read/208492>

21. Гэсэр (Нийтэд түгсэн тууль) МҮОНРТВ-ийн захиалгаар Өвархангайн Бүрд сум, 2017 онд Рузвельт арал дээр хайлагдсан.

